



## **НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

2019 болон 2020 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн эцсийн тайлан

*(Канад доллараар)*

Аудитын англи хэл дээрх тайлантай дараах SEDAR [www.sedar.com](http://www.sedar.com) дахь компанийн хуудаснаас танилцана уу.

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан  
(Канад доллараар)

	Тодруулга	2020.12.31	2019.12.31
<b>Хөрөнгө</b>			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		\$ 12,800,728	\$ 5,106,863
Дансны авлага		89,344	70,361
Урьдчилж төлсөн зардал		212,479	69,029
Эргэлтийн хөрөнгийн дүн		13,102,551	5,246,253
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	5	29,364,155	21,483,517
Хөрөнгө ашиглах эрх	6	107,693	137,064
Үндсэн хөрөнгө	7	239,431	105,998
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		29,711,279	21,726,579
<b>Нийт хөрөнгийн дүн</b>		<b>\$ 42,813,830</b>	<b>\$ 26,972,832</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмч</b>			
Арилжаа болон бусад өглөг		\$ 582,356	\$ 591,999
Түрээсийн өглөг	6	27,853	25,697
Богино хугацаат өр төлбөр		610,209	617,696
Түрээсийн өглөг	6	85,699	113,553
Хөрвөх боломжтой зээл	9	-	6,260,521
Урт хугацаат өр төлбөр		85,699	6,374,074
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>		<b>695,908</b>	<b>6,991,770</b>
<b>Эздийн өмч</b>			
Хувьцаат капитал	11	\$ 136,618,086	\$ 109,466,565
Нэмж төлөгдсөн капитал		25,937,667	16,829,920
Хуримтлагдсан ба бусад алдагдал		(2,964,666)	(1,958,616)
Алдагдал		(117,473,165)	(104,356,807)
<b>Эздийн өмчийн дүн</b>		<b>42,117,922</b>	<b>19,981,062</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>		<b>\$ 42,813,830</b>	<b>\$ 26,972,832</b>

Гэрээгээр хүлээсэн үүрэг (Тодруулга 8)

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

Төлөөлөн Удирдах Зөвлөл (“ТУЗ”)-ийг төлөөлж баталсан:  
Гарын үсэг зурсан “Петер К.Акерли”

ТУЗ-ийн гишүүн

Гарын үсэг зурсан “Жон П.Бюрн”

ТУЗ-ийн гишүүн

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн Алдагдлын Дэлгэрэнгүй Тайлан  
(Канад доллараар)

Тодруулга	тасалбар болгосон өдөр 12 сарын 31	
	2020	2019
<b>Үйл ажиллагааны зардал</b>		
Хайгуул, үнэлгээний зардал	\$ 1,372,811	\$ 1,090,786
Ерөнхий болон удирдлагын зардал	1,868,905	1,615,724
Үйл ажиллагаанаас учирсан алдагдал	3,241,716	2,706,510
Санхүүгийн орлого	(62,858)	(36,512)
Хүүгийн зардал	1,661,960	165,934
Санхүүгийн хэрэгслээс үүдсэн үнэ цэнийн зөрүү	8,508,076	(178,972)
Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз (олз)	(232,536)	26,332
<b>Цэвэр алдагдал</b>	<b>\$ 13,116,358</b>	<b>\$ 2,683,292</b>
Бусад дэлгэрэнгүй алдагдал:		
Охин компанийн хөрвүүлгээс үүдсэн гадаад валютын ханшийн зөрүү	1,006,050	1,002,903
<b>Бусад дэлгэрэнгүй алдагдал</b>	<b>1,006,050</b>	<b>1,002,903</b>
<b>Нийт дэлгэрэнгүй алдагдал</b>	<b>\$ 14,122,408</b>	<b>\$ 3,686,195</b>
Нэгж хувьцаанд ногдох суурь алдагдал	\$ 0.06	\$ 0.02
Нийт хувьцааны жигнэсэн дундаж тоо	216,535,792	178,522,823

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Өмчийн өөрчлөлтийн тайлан  
(Канад доллараар)

	Тодр уулга	Хувьцааны тоо ширхэг	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан бусад дэлгэрэнгүй алдагдал	Алдагдал	Нийт эздийн өмч
<b>2019.01.01-ний үлдэгдэл</b>		162,426,416	\$ 104,003,644	\$ 16,110,116	\$ (955,713)	\$ (101,673,515)	\$ 17,484,532
<b>Тайлант хугацааны нийт алдагдал:</b>							
Цэвэр алдагдал		-	-	-	-	(2,683,292)	(2,683,292)
Бусад дэлгэрэнгүй алдагдал		-	-	-	(1,002,903)	-	(1,002,903)
Хаалттай хүрээнд гаргасан хувьцааны цэвэр зардал	11	25,922,044	4,895,464	414,401	-	-	5,309,865
Хэрэгжсэн опцион	11	1,105,000	276,900	(107,100)	-	-	169,800
ИОХЭ-ийн төлөвлөгөөний дагуу гаргасан энгийн хувьцаа	11	1,615,030	290,557	(290,557)	-	-	-
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр		-	-	703,060	-	-	703,060
<b>Эзэмшигчидтэй хийсэн нийт хэлцэл гүйлгээ</b>		28,642,074	5,462,921	719,804	-	-	6,182,725
<b>2019.12.31-ний үлдэгдэл</b>		191,068,490	\$ 109,466,565	\$ 16,829,920	\$ (1,958,616)	\$ (104,356,807)	\$ 19,981,062
<b>2020.01.01-ний үлдэгдэл</b>		191,068,490	\$ 109,466,565	\$ 16,829,920	\$ (1,958,616)	\$ (104,356,807)	\$ 19,981,062
<b>Тайлант хугацааны нийт алдагдал:</b>							
Цэвэр алдагдал		-	-	-	-	(13,116,358)	(13,116,358)
Бусад дэлгэрэнгүй алдагдал		-	-	-	(1,006,050)	-	(1,006,050)
Хаалттай хүрээнд гаргасан хувьцааны цэвэр зардал	11	44,444,441	10,727,732	8,206,644	-	-	18,934,376
Хөрвүүлэх боломжит зээлийн хүрээнд гаргасан энгийн хувьцаа	9	30,043,290	15,768,935	-	-	-	15,768,935
	11	2,175,000	521,890	(177,590)	-	-	344,300
ИОХЭ-ийн төлөвлөгөөний дагуу гаргасан энгийн хувьцаа	11	719,212	132,964	(132,964)	-	-	-
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр		-	-	1,211,657	-	-	1,211,657
<b>Эзэмшигчидтэй хийсэн нийт хэлцэл гүйлгээ</b>		77,381,943	27,151,521	9,107,747	-	-	36,259,268
<b>2020.12.31-ний үлдэгдэл</b>		268,450,433	\$ 136,618,086	\$ 25,937,667	\$ (2,964,666)	\$ (117,473,165)	\$ 42,117,922

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан  
(Канад доллараар)

Тодруулга	Тайлант хугацаа 12 сарын 31	
	2020	2019
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Цэвэр алдагдал	\$ (13,116,358)	\$ (2,683,292)
Мөнгөн бус гүйлгээнүүд:		
Элэгдэл, хорогдол	54,632	32,248
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр	1,211,657	703,060
Санхүүгийн орлого	(62,858)	(36,512)
Хүүгийн зардал	9 1,653,178	162,051
Мөнгөн бус гадаад валют	(232,536)	26,332
Хөрвөх нөхцөлтэй өр төлбөрийн үнэ цэнийн өөрчлөлт	8,508,076	(178,972)
Мөнгөн бус эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт	(172,509)	392,315
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(2,156,718)	(1,582,770)
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Энгийн хувьцаагаар татан төвлөрүүлсэн цэвэр дүн	11 18,934,376	5,309,865
Хөрвөх нөхцөлтэй зээлийн гэрээгээр татан төвлөрүүлсэн цэвэр дүн	9 -	6,357,763
Опцион хэрэгжүүлсний төлбөр	11 344,300	169,800
Түрээсийн төлбөрийн эргэн төлөлт	(25,698)	(7,604)
Хөрвөх нөхцөлтэй зээлийн хүү	9 (608,302)	-
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	18,644,676	11,829,824
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Хайгуул, хөрөнгийн үнэлгээний зардал	(8,873,361)	(6,804,128)
Үндсэн хөрөнгө, үйлдвэр, тоног төхөөрөмжийн зардал	(175,630)	(10,653)
Хүүгийн орлого	62,858	36,512
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(8,986,133)	(6,778,269)
Валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	192,040	(110,171)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн өсөлт (бууралт)	7,693,865	3,358,614
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, хугацааны эхэнд	5,106,863	1,748,249
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, хугацааны эцэст	\$ 12,800,728	\$ 5,106,863

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2019 болон 2020 оны 12 сарын 31-ний жилийн эцсийн тайлан

---

## 1. Үйл ажиллагааны тухай:

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (“Эрдэнэ Ресурс” “Корпораци” эсвэл “Компани” гэх) нь Канад Улсад төвтэй, үнэт болон суурь металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагааг Монгол Улсад эрхэлдэг компани юм. Компанийн үнэт цаас нь Торонтогийн Хөрөнгийн Биржид “ERD”, Монголын Хөрөнгийн Биржид “ERDN” тикертэйгээр арилжаалагддаг. Компанийн албан хаяг нь 1300-1969 Upper Water Street, Halifax, Nova Scotia, B3J 2V1.

Эрдэнэ Ресурс нь үнэт болон суурь металлын хайгуул, хөрөнгө оруулалт болон төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагааг Монгол Улсын баруун өмнөд бүсэд эрхэлдэг. Компанийн голлох төсөл нь Монгол Улсын Баянхонгор аймагт орших Баян Хөндий Алтны Төсөл юм.

2020 оны 08 дугаар сард Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий Алтны Төслийн хараат бус нарийвчилсан ТЭЗҮ-ийн үр дүнг танилцуулсан. Компанийн үйл ажиллагаа үргэлжлэх, ашигт малтмалын өмчид капиталжуулсан хөрөнгийг нөхөн олох эсэх нь эдийн засгийн хувьд ашигтай нөөц, компанийн хайгуул, бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай санхүүжилтийг олох чадвар болон үйлдвэрлэлийн эдийн засгийн үр ашигтай байдал эсвэл нэг буюу түүнээс дээш хөрөнгийн худалдаанаас олсон орлого зэргээс хамаарна.

## 2. Тайлан бэлтгэсэн суурь

### а) Мөрдсөн стандарт

Нэгтгэсэн санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу бэлтгэсэн болно. Тодруулга 4-т дурдсанаас гадна бүх санхүүгийн жилүүдэд тогтвортойгоор мөрдөгдсөн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг тодруулга 3-д толилуулсан.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг ТУЗ-ийн 2020 оны 3 сарын 11-ний өдрийн шийдвэрээр батлан гаргасан.

### б) Хэмжилтийн суурь

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ худалдах боломжтой санхүүгийн хөрөнгө, бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн ашиг, алдагдлыг оролцуулахгүйгээр түүхэн өртгийн сууриар бэлтгэсэн. Мөнгөн гүйлгээнээс бусад мэдээлэл нь нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт бүртгэлээр бэлтгэсэн болно.

### с) Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцооллууд

Санхүүгийн тайланг бэлтгэх явцад Компанийн удирдлага нь тайлан болон холбогдох тодруулгуудтай холбоотойгоор материаллаг өөрчлөлт, нөлөө үзүүлэх тооцоолол, таамаглалууд дэвшүүлэхийг шаарддаг. Үнэлэмж, тооцооллууд нь олон хүчин зүйлд үндэслэх бөгөөд түүхэн туршлага, одоогийн болон хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн нөхцөл байдал гэх мэт мэдээллүүдийг ашигласан. Бодит үр дүн нь эдгээр тооцооллоос зөрөх магадлалтай. Удирдлагын тооцоолол болон таамаглал, үндэслэл, төсөөлөл болон эдгээр нь нягтлан бодох бүртгэлийн стандарт, тодруулгуудад хэрхэн нөлөөлөх талаар доор танилцуулав.

- i) *Төлбөрийн хэрэгсэл, валют:* Санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгасан Компани болон охин компани тус бүр нь үйл ажиллагаа явуулахад анхдагч зах зээлийн валютыг ашигладаг. Толгой компани канад доллар, Монгол дахь охин компаниуд монгол төгрөгөөр үйл ажиллагаа эрхэлдэг.
- ii) *Хайгуул, үнэлгээний хөрөнгийн үнэ цэн бууралтын тооцоолол:* Хайгуул, үнэлгээний хөрөнгүүдийг тайлант хугацаа бүрт үнэ цэнээ алдсан эсэхийг шалгадаг. Үнэ цэнийн бууралтын үзүүлэлтүүд байгаа эсэхийг шалгах шаардлагатай бөгөөд үүнд” хайгуул хийх эрхтэй хугацаа, хайгуулын эрхийг сунгах, нөөцийг үнэлэх болон хайгуулын зарцуулалтын томоохон зардлуудыг төсөвлөсөн эсэх, хайгуул, үнэлгээний хөрөнгөнд багтсан хайгуул, үнэлгээний үр дүнгүүд зэрэг хүчин зүйлийг багтаана.

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2019 болон 2020 оны 12 сарын 31-ний жилийн эцсийн тайлан

---

## 2. Тайлан бэлтгэсэн суурь (үргэлжлэл)

Үнэ цэнийн бууралтад орсон байх шинж тэмдэг байгаа гэж үзсэн үед бодит үнэ цэнийн дүнгээс борлуулах зардал болон ашиглалтын өртгийг хассан дүнгийн аль өндөр дүнг харгалзаж хөрөнгөөс цуглуулан авах боломжтой дүнг тооцоолно. Үнэ цэнийн бууралтын шинжилгээг хийхдээ дараах тооцоолол, төсөөллүүдийг ашиглана, үүнд: урт хугацааны таваарын зах зээлийн үнэ, хорогдуулах хувь хэмжээ, ирээдүйн хөрөнгийн зардал, хайгуулын боломж болон үйл ажиллагааны зардлыг багтаана. Хайгуулын болон үнэлгээний хөрөнгийн бодит үнэ цэнийг ирээдүйн тэлэх төлөвлөгөөний зардал, борлуулалт болон хараат бус зах зээлийн оролцогч хэмээн хөрөнгийн ашиглалтын ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнээр тодорхойлно. Мөнгөн гүйлгээг мөнгөний цаг хугацааны үнэ цэн, хөрөнгийн эрсдэлийн өнөөгийн зах зээлийн үнэлгээг тусгасан татварын өмнөх хорогдуулалтын түвшинг ашиглан, өнөөгийн үнэ цэнд хорогдуулалт хийнэ. Хэрэв компани нь эрдсийн нөөцийн хөрөнгийн тухай хангалттай мэдээлэл байхгүй бол ижил төстэй хөрөнгүүдтэй харьцуулах, эсвэл салбарын жишиг үзүүлэлтүүдээр тооцоолж болно.

- iii) *Хөрөнгө худалдан авалт: Компани нь хайгуулын болон үнэлгээний хөрөнгийг худалдан авах, эсвэл бизнесийн нэгдлийн хүрээнд нэгтгэх зэргийг тодорхойлж, шийдвэр хэрэгжүүлнэ. Ингэхдээ, үйлдвэрлэлийн нөөцийг тодорхойлсон эсэх, төслийг зах зээлийн бие даасан оролцогч болгон удирдах боломжтой эсэх, геологийн нөөцөөс үйлдвэрлэлийн нөөц рүү шилжүүлэхэд нэмэлт ажлууд хийх шаардлагатай эсэх хүчин зүйлсийг харгалзан үзнэ. Компани нь өнөөг хүртэл худалдан авсан хайгуул, үнэлгээний хөрөнгийн хөрөнгө худалдан авалт гэж үзэв.*
- i) Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр: Үнэт цаас, хувьцаанд суурилсан төлбөрийг олгож буй өдрийн бодит үнэ цэнээр хэмждэг. Бодит үнэ цэнийг Блэк-Шолсийн ("Black-Scholes pricing model") үнэлгээний загварыг ашиглаж тооцоолдог ба энэ нь хүлээгдэж буй хэлбэлзэл, бусад хувьсагчидтай холбоотой зах зээлд бэлэн буй мэдээлэлд үндэслэж шийдэл, дүгнэлт гаргахыг шаарддаг.
- ii) Хөрвөх нөхцөлтэй өр төлбөр: 2019 онд Эрдэнэ Ресурс нь хөрвүүлэлт хийх сонголттой дериватив опцион бүхий өрийн бичиг гаргасан ба эзэмшигч нь цаашид хэсэгчлэн ба бүхэлд нь компанийн энгийн хувьцаанд хөрвүүлэх боломжтой. Энэхүү хөрвөх боломжтой зээлийг удирдлага өр төлбөр хэмээн тодорхойлсон. Өр төлбөрийг бодит үнэ цэнд тулгуурлан бүртгэсэн бөгөөд тайлант хугацаануудад үнэлгээг дахин хийсэн. Бодит үнэ цэнийг бином опционы моделээр үнэлэн, бодит үнэ цэнийг үнэлэх хугацаанд боломжтой мэдээлэлд тулгуурлан өөрчлөлтийн магадлал, эрсдэлгүй хүүгийн түвшин болон зээлийн эрсдэл зэргийг харгалзан тооцоолсон.
- iii) Нөхөн сэргээлтийн тухай: Удирдлагын зүгээс жилийн хугацаанд бий болсон баримт, нөхцөлд үндэслэн талбайн нөхөн сэргээлтийн тухай шийдвэр гаргах шаардлагагүй гэж үзсэн.

### с) Ковид-19

2020 оны 3-р сарын 11-нд Ковид-19 тархалтыг Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас цар тахал хэмээн зарласан. Энэхүү цар тахлын дэгдэлтийг хязгаарлах оролдлогууд нь түүхий эдийн болон олон улсын хөрөнгийн зах зээлд томоохон нөлөө үзүүлсэн. Компани нь Ковид-19-ийн хүрээнд алсын зайнаас ажиллах, томилолтын хязгаарлалт, ариутгалын ажлуудыг нэмэгдүүлэх үйл ажиллагааны журмуудыг батлан ажилласан. Энэхүү ажлуудын үр дүнд цар тахал нь компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд томоохон нөлөөлөл үзүүлээгүй. Ажлын байрны аюулгүй байдлыг хангах талаар идэвх санаачилгатай ажиллаж байгаа боловч ирээдүйд Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдлын үр дүнд сөргөөр нөлөөлөх боломжтой. Корпораци нь 2020 оны 12 сарын 31-ний байдлаар \$12,492,342-ын эргэлтийн хөрөнгөтэй байсан нь энэхүү тодорхойгүй нөхцөл байдлыг даван туулахуйц хөрвөх чадвартай хэмээн үзэж байна.



# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2019 болон 2020 оны 12 сарын 31-ний жилийн эцсийн тайлан

### 3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын дүгнэлт

Дараах нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь хэрэв өөрөөр дурдаагүй бол эдгээр бодлогууд нь тайлагнасан бүх хугацаанд тууштай хэрэглэгдэнэ.

#### а) Нэгдсэн тайлан бэлтгэсэн суурь

2019, 2020 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн жилийн хувьд санхүүгийн нэгдсэн тайланд Эрдэнэ Ресурс Девелопмент Компани болон түүний охин компаниуд багтсан. Үүнд: Эрдэнэ Монгол ХХК, Аниан Ресурс ХХК (Монголын хайгуулын компаниуд) багтсан.

Охин компаниудыг толгой компани удирддаг бөгөөд удирдлагыг шилжүүлэх хүртэл санхүүгийн тайлагналд охин компаниудын санхүүгийн тайланг тусгана. Компани дундын үлдэгдэл, гүйлгээнүүд болон хэрэгжээгүй орлого, зарлагыг санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгаагүй. Санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд компани хоорондын үлдэгдэл гүйлгээг хасдаг. Үнэ цэнийн бууралтын нотолгоо байхгүй тохиолдолд бодит бус алдагдал нь бодит бус ашигтай адил аргаар хасагддаг.

#### б) Гадаад валют

Компанийн үйл ажиллагааны бүртгэлийн валют нь Компани болон охин компани тус бүрийн үйл ажиллагаа явуулж буй улсын үндэсний мөнгөн тэмдэгтийг ашигладаг. Хуулийн этгээд тус бүрийн санхүүгийн тайланг бэлтгэж байхад хуулийн этгээдийн ашигладгаас өөр валютаар (гадаад валют) хийсэн гүйлгээг тухайн өдрийн ханш давамгайлж буй валютаар тооцно. Тайлангийн төгсгөл бүрт гадны валютаар хийгдсэн бүртгэлүүд нь тухайн өдрийн валютын ханшаар дахин хөрвүүлэгдсэнээр нэгдсэн алдагдлын дэлгэрэнгүй тайланд валютын зөрүүний олз эсхүл гарз хэмээн бүртгэх үндэслэл болно.

Валютын ханшийн өндөр зөрүүтэйгээс бусад үед орлого зардлын зүйлсийг тухайн хугацааны дундаж валютын ханшаар тооцно. Валютын ханш өндөр зөрүүтэй үед гүйлгээ хийгдсэн өдрийн ханшаар тооцно. Үнэт цаасны гүйлгээ хийх тохиолдолд гүйлгээ хийсэн тухайн өдрийн ханшаар тооцно. Гадаад валютаар тооцогдсон хөрөнгө, өр төлбөрийн хувьд валютын зөрүү гарсан тохиолдолд бусад хуримтлагдсан хөрвүүлгийн залруулгын орлого (алдагдал)-д тооцогдоно.

Гадны үйл ажиллагааны хяналтын алдагдлын хувьд бүх ханшийн зөрүүг Компанийн эзэмшигчидтэй холбоотой үйл ажиллагааны өмчөөр хуримтлуулсан ба орлогын тайланд борлуулалтын ашиг эсвэл алдагдал байдлаар бичсэн.

#### с) Санхүүгийн хэрэглүүр

Санхүүгийн хэрэглүүр нь СТОУС 7, Санхүүгийн хэрэглүүр: Тайлагнал, НББОУС 32, СТОУС 9, санхүүгийн хэрэглүүрийн тайлагналын дагуу боловсруулагдан, тайлагнагдсан. Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээс бусдаар санхүүгийн хөрөнгө, өр төлбөр нь гүйлгээний зардал, анхны хүлээн зөвшөөрөлтийг нэмсэн бодит үнэ цэнээр тооцогдоно. Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр тодорхойлогдсон санхүүгийн хөрөнгө нь гүйлгээний зардал, анхны хүлээн зөвшөөрөлтийг зарлагадсан бодит үнэ цэнээр тооцогдоно.

Үнэ цэнийг ангилахдаа тухайн нийт үнэ цэнийг бүрдүүлж буй доод зардалд тулгуурладаг. Дараах мэдээлэлд Компанийн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг ангилж, хэмжих нэгжээр илэрхийлэв.

Төрөл	Ангилал	Хэмжих нэгж
Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах	Санхүүгийн хөрөнгө	Бодит үнэ цэн
Авлага	Санхүүгийн хөрөнгө	Элэгдэл тооцсон зардал
Худалдаа болон бусад өглөг	Санхүүгийн өр төлбөр	Элэгдэл тооцсон зардал
Хөрвөх нөхцөлтэй зээл	Санхүүгийн өр төлбөр	Элэгдэл тооцсон зардал
Хөрвөх нөхцөлтэй зээл – хөрвөх опцион	Санхүүгийн өр төлбөр	Бодит үнэ цэн

Компани нь санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээний гэрээний эрх дуусгавар болох эсвэл санхүүгийн хөрөнгө, түүнийг өмчлөхтэй холбоотой бүхий л эрсдэл, өгөөжийг бусад хуулийн этгээдэд шилжүүлэх үед тайлангаас хасна.

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

2019 болон 2020 оны 12 сарын 31-ний жилийн эцсийн тайлан

## 3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын дүгнэлт (үргэлжлэл)

Компани нь өр төлбөрийг өр төлбөрийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх, цуцлах, хугацаа дуусах үед тайлангаас хасна. Хассан өр төлбөрийн дансны дүн ба төлсөн, төлөх өр төлбөрийн (бэлэн бус хөрөнгө шилжүүлсэн, өр төлбөрийг төлсөн) зөрүүг цэвэр (алдагдал) орлогын нэгдсэн тайланд бүртгэнэ. Хөрвөх нөхцөлтэй зээлийн өр төлбөрийн хөрвүүлэлтийг тооцохдоо, Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого нь хөрвүүлэлтээс өмнө шууд хөрвөх нөхцөлтэй зээлийн дансны үнээр гаргасан үнэт цаасыг хэмжихэд чиглэдэг бөгөөд ангилал өөрчлөгдөх, ашиг алдагдлыг хүлээн зөвшөөрөхгүй.

### d) Хайгуул, үнэлгээний хөрөнгө

Хайгуулын өмнөх зардлыг зардлаар хүлээн зөвшөөрдөг. Эрдсийн нөөц тогтоохтой холбоотой бүх шууд зардлыг хайгуулын төсөл тус бүрээр катипалжуулна. Хайгуулын төсөл эсвэл талбайн боломжийг тодорхойлж, ТУЗ-өөр батлагдаж хайгуул, үнэлгээний зардал капиталжих хүртэлх хугацаанд гарсан хайгуулын зардлыг үйл ажиллагааны зардлаар зарлагадна.

Хайгуул, үнэлгээний хөрөнгийг эхлээд зардал байдлаар хэмжин, биет хөрөнгөөр ангилдаг. Хайгуул, үнэлгээний хөрөнгөнд: хайгуул, судалгаа хийх, хайгуулын өрөмдлөг, суваг малталт, дээж авах эрхийг олж авах болон төслийн хайгуул, үнэлгээтэй холбоотой бусад шууд зардлууд орно. Төсөл нь техник эдийн засгийн болон арилжааны үүднээс үр ашигтай эсэхийг тодорхойлон, тодорхой ашиг сонирхолтой холбоотой ажлыг гүйцэтгэх шийдвэр гарсан бол холбогдох хайгуул, үнэлгээний хөрөнгийг үнэ цэнийн бууралтаар нь туршиж, балансыг нөөцийн төсөл, үйлдвэр, тоног төхөөрөмжид дахин ангилна.

Хайгуул, үнэлгээний үнэ цэнийн бууралтыг нягтлахдаа хөрөнгийн дансны дүн нь нөхөн төлөгдөх дүнгээс давж байвал тус бүрээр нь эсвэл мөнгө бий болгох нэгжийн түвшинд дахин нягтална. Үүнийг бий болоход, тодорхойлсон санхүүгийн жилд дансны дүнгийн эсрэг бүрэн барина.

Эрдсийн нөөцийг олборлох техникийн үндэслэл, эдийн засгийн үр өгөөж нь тодорхойлогдсон тохиолдолд хайгуул, үнэлгээний хөрөнгийг дээрх байдлаар ангилахгүй. Хайгуул болон үнэлгээний хөрөнгийг дахин ангилахаас өмнө үнэ цэнийн бууралт, эсвэл үнэ цэнийн бууралтын алдагдлын хүлээн зөвшөөрөх шаардлагатай.

Хайгуул, үнэлгээний хөрөнгийг тогтмол дахин үнэлдэг ба эдгээр зардлыг хамгийн багадаа дараах нөхцөлүүдийн аль нэгийг хангасан үед шилжүүлнэ:

- i) Эдгээр зардлууд нь хайгуул болон хөгжүүлэлт хийх боломжтой газрыг буцааж авах эсвэл худалдан авах; эсвэл
- ii) Хайгуул, үнэлгээний үйл ажиллагаа хийх боломжтой газар нь үнэлгээний эсвэл бусад эдийн засгийн нөхөн төлөгдөх баталгаагүй, нөөцийн шатандаа хараахан хүрээгүй мөн идэвхтэй, чухал үйл ажиллагаа тухайн талбайд үргэлжлээгүй эсвэл ирээдүйд төлөвлөгдөөгүй.

### e) Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралтын алдагдлын зардлаар хэмждэг. Зардалд хөрөнгө авахтай шууд холбоотой өртгүүд багтана. Өөрөө барьж байгуулсан хөрөнгийн өртөгт: материалын өртөг, хөдөлмөрийн зардал болон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах нөхцөлийг бий болгоход шууд хамаарах бусад зардал багтдаг.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцоолохдоо тэдгээрийн зардал, үлдэх үнэ цэнийн цэвэр дүн, ашиглалтын тооцоолсон хугацааг хуваарилах бууралтын балансын аргаар тооцно:

Хөрөнгө	Суурь	Хэмжээ
Тээвэр, хээрийн хэрэгсэл	Буурах үлдэгдэл	30%
Тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил	Буурах үлдэгдэл	20%
Програм хангамж, компьютер	Буурах үлдэгдэл	33%

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2019 болон 2020 оны 12 сарын 31-ний жилийн эцсийн тайлан

---

## 3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын дүгнэлт (үргэлжлэл)

Шаардлагатай тохиолдолд элэгдлийн аргууд, ашиглалтын хугацаа, үлдэх үнэ цэнийн дүнг санхүүгийн жилийн төгсгөл тутамд хянаж тохируулна.

### f) Түрээс

Гэрээ байгуулах үед Эрдэнэ Ресурс нь тухайн гэрээ нь түрээсийн талаар заалт, эсвэл тодорхой хугацаанд хөрөнгө эзэмших эрхийг шилжүүлж байгаа эсэхэд үнэлгээ хийдэг. Гэрээ нь байгуулагдсан цагаас эхлэн үл хөдлөх хөрөнгө, үйлдвэр, тоног төхөөрөмж болон санхүү тайлангийн урт хугацааны өр төлбөр дэх түрээстэй холбоотой өр төлбөр эзэмших эрх шилжих тохиолдолд түрээсийн гэрээ хэмээн авч үзнэ.

Хөрөнгө ашиглах эрхийг тооцоолохдоо түрээсийн өр төлбөрийг анх хэмжих үеийн зардал, эхлэх өдрөөс өмнө хийгдсэн аливаа төлбөр багтаж, хүлээн авсан түрээсийн урамшуулал, нөхөн сэргээх зардал болон анхны шууд өртгийг хасаж тооцно. Хөрөнгө ашиглах эрхийг түрээсийн хугацааны туршид шулууншугамын үндсэн дээр элэгдүүлэн тооцно.

Хөрөнгө ашиглах эрхийг тооцоолохдоо түрээсийн өр төлбөрийг анх хэмжих үеийн зардал, эхлэх өдрөөс өмнө хийгдсэн аливаа төлбөр багтаж, хүлээн авсан түрээсийн урамшуулал, нөхөн сэргээх зардал болон анхны шууд өртгийг хасаж тооцно. Хөрөнгө ашиглах эрхийг түрээсийн хугацааны туршид шулууншугамын үндсэн дээр элэгдүүлэн тооцно. Түрээсийн зохих өр төлбөрийг гэрээ хийгдсэн хугацааны үед төлөгдөөгүй түрээсийн өнөөгийн үнэ цэн, түрээсийн хүүгийн далд төлбөрөөр хөнгөлсөн эсвэл тухайн хувь хэмжээг тогтоох боломжгүй бол Эрдэнэ Ресурсийн зээлийн өрийн нэмэгдлийн хувь хэмжээ, зах зээлийн харьцуулалтад тулгуурлан тооцоолно. Түрээсийн төлбөрт тогтмол төлбөрүүд, гэрээ хийгдсэн хугацааны үеийн индекс болон үнэлгээнээс хамааран хувьсах төлбөр, үлдсэн үнэ цэнийн баталгааны дагуу хүлээгдэж буй төлбөр, хэрэгжүүлэх боломжтой худалдах опцион хэрэгжүүлэх зэрэг багтана. Түрээсийн өр төлбөрийг зах зээлийн хүүгийн аргаар элэгдүүлсэн зардлаар тооцно.

Эрдэнэ Ресурс нь түрээсийг нягтлан бодох бүртгэлд дараах байдлаар тусгахаар зорилтуудыг тодорхойлсон.

- i) Салгах боломжтой бүрэлдэхүүн – Эрдэнэ Ресурс нь түрээсийн бус бүрэлдэхүүнийг түрээсийн бүрэлдэхүүнээс салгахгүй байхаар шийдсэн бөгөөд түрээсийн бүрэлдэхүүн болон түүнтэй холбогдох түрээсийн бус бүрэлдэхүүнийг нийтэд нь түрээсийн бүрэлдэхүүн хэмээн авч үзнэ.
- ii) Богино хугацааны түрээс – Эрдэнэ Ресурс нь 12 сар болон түүнээс бага хугацаатай түрээсийн чөлөөлөлтийг хүлээн зөвшөөрсөн.

### g) Хувьцаанд суурилсан төлбөр

Ажилтнуудын урамшуулал болгон олгосон хувьцаанд суурилсан нөхөн төлбөрийг олгосон өдрийн бодит үнэ цэнээр Блэк Шолсийн үнэлгээний загварыг ашиглан тооцно. Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр бодит үнэ цэнийг бүртгэх үед мэдэгдэж буй мэдээлэлд тулгуурлан хүлээгдэж буй хэлбэлзэл болон хүлээгдэж буй хугацаа гэх мэт хувьсагчуудын хүрээнд тооцогддог.

Ажилтнуудын урамшууллаас бусад хувьцаанд суурилсан нөхөн төлбөрийн гүйлгээ болон ижил төстэй урамшуулал, үйлчилгээ үзүүлж буйг зах зээлийн үнийг найдвартай тооцоолж чадахгүйгээс бусад тохиолдолд хүлээн авсан бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийн бодит үнээр хэмждэг.

### h) Нэгж хувьцаанд ногдох алдагдал

Компани нь энгийн хувьцаанд ногдох суурь болон хорогдуулсан нэгж хувьцааны алдагдлыг тайлагнадаг. Нэгж хувьцааны суурь алдагдлыг тооцоолохдоо энгийн хувьцаа эзэмшигчидтэй холбоотой ашиг болон алдагдлыг тухайн хугацаанд зах зээлд буй нийт хувьцааны жигнэсэн дундаж тоонд харьцуулан тооцно. Нэгж хувьцааны хорогдуулсан алдагдлыг энгийн хувьцаа эзэмшигчдийн тохируулсан ашиг болон алдагдлыг хорогдуулах боломжтой нийт энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоонд харьцуулан, тохируулж тооцно. Бүх хувьцааны опцион нь өнөөгийн байдлаар хорогдуулах боломжит алдагдалд

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2019 болон 2020 оны 12 сарын 31-ний жилийн эцсийн тайлан

---

## 3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын дүгнэлт (үргэлжлэл)

орохгүй. Ингэснээр нэгж хувьцааны суурь болон хорогдуулах боломжит алдагдал нь адил хэмжээнд байна.

Компани нь опцион, варрант болон бусад хэрэгслүүдийн хорогдуулах үр нөлөөг тооцохдоо төрийн сангийн хувьцааны аргыг ашигладаг. Энэхүү аргаар: нэгж хувьцааны хорогдуулсан алдагдлыг тооцоолоход ашигласан хувьцааны жигнэсэн дундаж тоо нь хувьцааны опцион хэрэгжүүлсэн, хувьцаа худалдан авах варрант, түүнтэй адилтгах хөрөнгийг ашигласнаас олсон орлогыг Компанийн энгийн хувьцааг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр буцаан худалдан авахад ашиглана хэмээн тооцоолсон. Бүх хувьцааны опционууд нь нэг хувьцааны алдагдлыг хорогдуулах боломжгүй бөгөөд үүний үр дүнд нэгж хувьцааны алдагдал болон хорогдуулсан алдагдал ижил байна.

## 4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөгдсөн стандартууд болон тайлбарууд

2020 оны 1 дүгээр сарын 1-нээс дараах шинэ стандарт, нэмэлт өөрчлөлт, тайлбар орж, хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Эдгээр өөрчлөлтүүдийг холбогдох шилжилтийн заалтуудын дагуу хийсэн.

НББОУС 1 – Санхүүгийн тайлан бэлтгэх болон НББОУС 8 – Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцоолол ба алдаа

2018 оны 10 сарын 31-ээс НББОУС 1 – Санхүүгийн тайлан бэлтгэх болон НББОУС 8 – Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцоолол ба алдаа стандартуудад НББОУС3-өөс өөрчлөлт оруулсан. Энэ нь СТОУС-ын хүрээнд материаллаг байдлын тодорхойлолтыг тодорхой болгох зорилготой. Энэхүү стандартыг мөрдөж эхэлснээр Компанид материаллаг өөрчлөлт орохгүй гэж үзэж байна.

СТОУС 3 – Бизнесийн Нэгдэл

2018 оны 10 сарын 22-оос эхлэн СТОУС 3 Бизнесийн нэгдэл стандартад өөрчлөлт оруулсан ба бизнесийн тодорхойлолтыг нарийвчлах, шалгалтыг нэвтрүүлэх зорилготой, энэ нь тодорхой тохиолдолд нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагагүй болгоно. Энэхүү нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлснээр Компанид материаллаг нөлөө үзүүлэхгүй.

*Мөрдөгдөж эхлээгүй байгаа нягтлан бодох бүртгэлийн шинэ стандартууд*

НББОУС-ийн дараах стандартууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэхэд ашиглагдаагүй бөгөөд хүчин төгөлдөр мөрдөгдөх хугацаа нь тайлангийн үеийн дараагийн жилээс эхэлнэ.

НББОУС 1 – Санхүүгийн тайлангийн толилуулга

2020 оны 1 сарын 23-нд НББОУС нь НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулгад өөрчлөлт оруулан, өр төлбөрийн ангиллыг илүү ерөнхий болгосон. Нэмэлт өөрчлөлтөөр өр төлбөрийг эргэлтийн болон эргэлтийн бус гэж ангилах нь өр төлбөрийг барагдуулах эрхийг хэрэгжүүлэх хүлээлтээс ялгаатай нь тайлант хугацааны эцэст үүссэн эрхээс хамаарна гэж тодотгосон. Энэхүү нэмэлт өөрчлөлтөөр төлбөр тооцоо нь харилцагч тал руу бэлэн мөнгө, өмчийн хэрэгсэл, бусад хөрөнгө болон үйлчилгээг шилжүүлэхийг хэлнэ гэж тодотгосон. Энэхүү нэмэлт өөрчлөлтийг 2023 оны 1 сарын 1-ний өдрөөс хойш хүчин төгөлдөр мөрдөх бөгөөд энэхүү хугацаанаас өмнө даган мөрдөхийг зөвшөөрсөн. Компани нь одоогоор нэмэлт өөрчлөлттэй холбоотой санхүүгийн үр нөлөөг үнэлж байгаа бөгөөд нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр хэрэгжих хугацаанаас эхлэн хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөсөн.

НББОУС 16 – Үндсэн Хөрөнгө

2020 оны 5 сарын 14-нд ОУСБХБ-аас НББОУС 16 - Үндсэн Хөрөнгөд нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд худалдан борлуулсан үндсэн хөрөнгө нь удирдлагаас тогтоосон үйл ажиллагааны нөхцөлд тохирох байршилд хүргүүлэх үед борлуулалтын орлогын дүнг үндсэн хөрөнгийн өртгөөс хасахыг хориглосон. Борлуулалтын орлого, үйлдвэрлэсэн өртгийг ашиг, алдагдалд бүртгэнэ. Нэмэлт өөрчлөлтийг 2022 оны 1 сарын 1-ээс хэрэгжүүлж эхлэх бөгөөд хэрэгжих хугацаанаас өмнө хэрэгжүүлж болно. Нэмэлт өөрчлөлт нь зөвхөн санхүүгийн тайланд тусгах хугацаанд болон удирдлагаас

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

2019 болон 2020 оны 12 сарын 31-ний жилийн эцсийн тайлан

## 4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөгдсөн стандартууд болон тайлбарууд (үргэлжлэл)

тогтоосон үйл ажиллагааны нөхцөлд тохирох хөрөнгийг байршилд хүргүүлэх үед зөвхөн өмч, барилга, тоног төхөөрөмж зэрэгт хамаарна. Компани нь одоогоор нэмэлт өөрчлөлттэй холбоотой санхүүгийн үр нөлөөг үнэлж байгаа бөгөөд нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр хэрэгжих хугацаанаас эхлэн хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөсөн.

### НББОУС 37 – Сан, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө

2020 оны 5 сарын 14-нд ОУСБХБ нь НББОУС 37 – Сан, болзошгүй өр төлбөр, хөрөнгөд нэмэлт өөрчлөлт оруулж, гэрээ нь нарийн түвэгтэй эсэхийг үнэлэх зорилгоор гэрээний биелэлтийн зардлыг тодорхойлоход аж ахуйн нэгж ямар зардлыг багтаахыг тодорхойлсон. Нэмэлт өөрчлөлтөөр гэрээний биелэлтийн өртөг нь гэрээний шууд хамааралтай зардлыг багтаана. Гэрээний шууд хамааралтай зардлууд нь гэрээний биелэлтийн нэмэгдэл зардал, гэрээний биелэлттэй шууд холбоотой зардлын хуваарилалт байж болно. Энэхүү нэмэлт өөрчлөлтийг 2022 оны 1 сарын 1-ээс хэрэгжүүлж эхлэх бөгөөд хэрэгжих хугацаанаас өмнө хэрэгжүүлж болно. Компани нь одоогоор нэмэлт өөрчлөлттэй холбоотой санхүүгийн үр нөлөөг үнэлж байгаа бөгөөд нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр хэрэгжих хугацаанаас эхлэн хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөсөн.

### СТОУС 9 – Санхүүгийн хэрэглүүр

2020 оны 5 сарын 14-нд ОУСБХБ нь СТОУС 9 – Санхүүгийн хэрэглүүрт нэмэлт өөрчлөлт оруулж, санхүүгийн өр төлбөрийг тооцохгүй байх эсэхийг үнэлэх тестэд ямар төлбөрийг хамруулахыг тодорхойлж өгсөн. Зөвхөн зээлдэгч ба зээлдүүлэгчийн хооронд төлсөн эсвэл хүлээн авсан шимтгэл, үүнд: аж ахуйн нэгж эсвэл зээлдүүлэгчийн аль нэгний өмнөөс төлсөн эсвэл авсан төлбөрүүд орно. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь 2022 оны 1 сарын 1-ээс хэрэгжүүлж эхлэх бөгөөд хэрэгжих хугацаанаас өмнө хэрэгжүүлж болно. Компани нь одоогоор нэмэлт өөрчлөлттэй холбоотой санхүүгийн үр нөлөөг үнэлж байгаа бөгөөд нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр хэрэгжих хугацаанаас эхлэн хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөсөн.

## 5. Хайгуул, үнэлгээний хөрөнгө

	Баян Хөндий	Алтан Нар	Зуун Мод	Улаан ба бусад	Нийт
2019.01.01 үлдэгдэл	\$ 10,947,301	\$ 2,955,725	\$ 831,726	\$ 952,596	\$ 15,687,348
Нэмэгдэл	5,951,335	767,125	67,091	18,577	6,804,128
Валютын ханшийн шилжилтийн нөлөө	(733,911)	(161,684)	(70,018)	(42,346)	(1,007,959)
2019.12.31 үлдэгдэл	\$ 16,164,725	\$ 3,561,166	\$ 828,799	\$ 928,827	\$ 21,483,517
2020.01.01 үлдэгдэл	\$ 16,164,725	\$ 3,561,166	\$ 828,799	\$ 928,827	\$ 21,483,517
Нэмэгдэл	7,436,420	391,875	64,512	980,554	8,873,361
Валютын ханшийн шилжилтийн нөлөө	(750,939)	(125,774)	(55,030)	(60,980)	(992,723)
2020.12.31 үлдэгдэл	\$ 22,850,206	\$ 3,827,267	\$ 838,281	\$ 1,848,401	\$ 29,364,155

Компанийн Монгол Улс дахь ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг Компанийн охин компаниуд болох Эрдэнэ Монгол ХХК, Аниан Ресорсиз ХХК, Лидер Эксплорэйшн ХХК эзэмшдэг. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл нь гурван жилийн хугацаанд хүчинтэй байх ба хугацааг 12 хүртэл жилээр сунгах боломжтой. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаатай олгодог бөгөөд 20 хүртэл жилээр 2 удаа сунгах боломжтой. Тусгай зөвшөөрлүүдийн жилийн төлбөрийг төлснөөр тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр байна.

### Баян Хөндий алтны төсөл

Баян Хөндий Алтны Төсөл нь Монгол Улсын Баянхонгор аймагт, Баян Хөндийн нөөцийг агуулсан 2,309 га ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг хамарч оршдог. 2019 оны 8 сард Монгол Улсын Ашигт Малтмал, Газрын Тосны Газар ("АМГТГ") нь Хөндий хайгуулын тусгай зөвшөөрлийн нэг хэсгийг хөрвүүлэх замаар Баян Хөндийн нөөцөд ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгосон. Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрөл нь Roma Oil and Mining Associates Limited-ийн боловсруулж, 2020 оны 8 сарын 31-нд

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2019 болон 2020 оны 12 сарын 31-ний жилийн эцсийн тайлан

---

## 5. Хайгуул, үнэлгээний хөрөнгө (үргэлжлэл)

танилцуулсан “Bayan Khundii Gold Project Feasibility Study NI 43-101 Technical Report” нэртэй тайлан дахь Баян Хөндийн геологийн ба үйлдвэрлэлийн нөөцийг багтаасан. Компани нь одоогоор бүтээн байгуулалтын бэлтгэл ажлуудыг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд 2021 онд бүтээн байгуулалтыг эхлүүлэхээр төлөвлөж байна.

Түүнээс гадна ашиглалтын тусгай зөвшөөрөлд Эрдэнэ Ресурсийн Алтан Сум, Хар Морь, Хойд Хөндий, Баруун Хөндий зэрэг хэтийн төлөв бүхий талбай багтаж байна. Компани нь 2016 оны 7 сарын 1-ээс капиталжуулах бодлогын дагуу хайгуулын зардлыг капиталжуулж эхэлсэн.

### Алтан Нар төсөл

Алтан Нар төсөл нь Монгол Улсын Баянхонгор аймагт, Эрдэнэ Ресурсийн Баян Хөндий алтны төслөөс хойд зүгт 16 км-т оршдог. Эрдэнэ Ресурс нь алт, мөнгө, хар тугалга, цайрын нөөц бүхий Алтан Нар төслийг агуулсан 4,669 га талбайг хамрах Цэнхэр Номин хайгуулын тусгай зөвшөөрлийг Алтан Нар ашиглалтын тусгай зөвшөөрөл болгон, 2020 оны 3 сарын 5-нд Ашигт Малтмал Газрын Тосны Газар бүртгэсэн. 2015 оны 1 сарын 1-нд Алтан Нарын анхан шатны нөөцийн тооцооллыг гүйцэтгэсэн бөгөөд Компани нь капиталын бодлогын дагуу хайгуулын зардлыг капиталжуулж эхэлсэн. Компани нь 2015 оноос өмнө зөвхөн Алтан Нартай холбоотой тусгай зөвшөөрлийн төлбөрийг капиталжуулж байсан.

### Зуун Мод зэс молибденийн төсөл

Зуун Мод төсөл нь Монгол Улсын Баянхонгор аймагт байрладаг. 6,041 га талбайг хамарсан тусгай зөвшөөрлийн талбайд молибден-зэсийн нөөц бүхий орд оршдог. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2011 онд олгосон. Молибденийн зах зээлийн үнэ нэмэгдэх үед Зуун Мод зэс-молибденийн төслийг хөгжүүлэх боломжтой бөгөөд Компани нь технологи ба зах зээлийн хүчин зүйлсийг магадлан судална.

### Улаан ба бусад

Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай нь Хөндий тусгай зөвшөөрлийн талбайтай хил залгаа, нийт 1,780 га талбайг хамардаг. Хайгуулын тусгай зөвшөөрөл нь 12 жилийн 6 дахь жилдээ хүчин төгөлдөр байгаа бөгөөд Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийн дагуу цаашид 12 жилийн хугацаа дуусахаас өмнө ашиглалтын тусгай зөвшөөрөлд шилжүүлэх боломжтой. 2017 оны 8 сарын 30-нд Эрдэнэ Ресурс нь Лидер Эксплорэйшн ХХК (Монгол улсын)-ийн 51%-ийг худалдаж авсан. Эрдэнэ Ресурс нь СТОУС 3-ийн дагуу үнэлгээ гаргасан бөгөөд үнэлгээгээр энэхүү гэрээ хэлцэл нь хөрөнгө худалдан авах ангилалд багтана (бизнес худалдан авах бус) гэсэн дүгнэлтэд хүрсэн. 2020 оны 12 сарын 10-нд Эрдэнэ Ресурс нь Улаан тусгай зөвшөөрлийн талбайг 100% эзэмших болж, Лидер Эксплорэйшн ХХК-ийн 49%-ийг \$750,000 ам.доллараар худалдан авсан.

Компани нь 2019 онд ашиглалтын тусгай зөвшөөрөлд шилжүүлсэн Хөндий тусгай зөвшөөрлийн талбайгаас 2,205 га талбайг хайгуулын тусгай зөвшөөрөл хэвээр үлдээсэн. Энэхүү хайгуулын тусгай зөвшөөрөл нь 12 жилийн 11 дэх жилдээ хүчин төгөлдөр байгаа бөгөөд Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийн дагуу цаашид 12 жилийн хугацаа дуусахаас өмнө ашиглалтын тусгай зөвшөөрөлд шилжүүлэх боломжтой.

## 6 Түрээс

Компани нь 2019 оны 9 сарын 1-ээс эхлэн 5 жилийн оффисын түрээсийн гэрээ хийсэн. Энэхүү түрээс нь баланс дээр түрээсийн өр төлбөр, хөрөнгө ашиглах эрх болон танилцуулсан. Түрээсийн хөнгөлөлт 7%-аар тооцсон.

Хөрөнгө ашиглах эрхийн талаар нэмэлт мэдээлэл:

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2019 болон 2020 оны 12 сарын 31-ний жилийн эцсийн тайлан

## 6 Түрээс (үргэлжлэл)

2019.01.01-нд	\$	-
Нэмэгдэл		146,854
Элэгдэл		(9,790)
<b>2019.12.31-нд</b>	<b>\$</b>	<b>137,064</b>
2020.01.01-нд	\$	137,064
Нэмэгдэл		-
Элэгдэл		(29,371)
<b>2020.12.31-нд</b>	<b>\$</b>	<b>107,693</b>

2020 оны 12 сарын 31-ний байдлаар төв оффисийн түрээсийн өр төлбөрийн хугацаа дуусах тухай:

	1 жилийн дотор	1 - 2 жил	2 - 3 жил	3 - 4 жил	Нийт
Түрээсийн төлбөр	\$ 34,522	\$ 34,693	\$ 35,037	\$ 23,358	\$ 127,610
Санхүүгийн зардлууд	(6,669)	(4,553)	(2,417)	(419)	(14,058)
<b>Нийт төлбөр</b>	<b>\$ 27,853</b>	<b>\$ 30,140</b>	<b>\$ 32,620</b>	<b>\$ 22,939</b>	<b>\$ 113,552</b>

Компанийн Монгол Улс дахь оффис болон ажилтнуудын байрны түрээс нь 12 сарын дотор хугацаа дуусна. Компани нь СТОУС 16-ын шаардлагыг эдгээр түрээсийн бүртгэлд тусгахгүй байхаар шийдсэн бөгөөд нийт \$89,803 (2019 - \$113,831) дүнтэй түрээсийн төлбөрийг гарсан зардлаар нь зардалд бүртгэсэн.

## 7. Үндсэн хөрөнгө

	Тээврийн ба хээрийн тоног төхөөрөмж	Тоног төхөөрөмж, тавилга	Програм хангамж, компьютер	Нийт
<b>Зардал</b>				
2019.01.01 үлдэгдэл	\$ 97,872	\$ 111,061	\$ 208,349	\$ 417,282
Нэмэгдэл	-	100	10,553	10,653
Валютын ханшийн шилжилтийн нөлөө	(7,691)	(3,721)	(2,075)	(13,487)
<b>2019.12.31 үлдэгдэл</b>	<b>\$ 90,181</b>	<b>\$ 107,440</b>	<b>\$ 216,827</b>	<b>\$ 414,448</b>
<b>Элэгдэл ба хорогдол</b>				
2019.01.01 үлдэгдэл	\$ (21,125)	\$ (82,436)	\$ (188,444)	\$ (292,005)
Элэгдэл	(9,431)	(4,466)	(8,561)	(22,458)
Валютын ханшийн шилжилтийн нөлөө	2,073	2,184	1,756	6,013
<b>2019.12.31 үлдэгдэл</b>	<b>\$ (28,483)</b>	<b>\$ (84,718)</b>	<b>\$ (195,249)</b>	<b>\$ (308,450)</b>
<b>Дансны дүн</b>				
2019.01.01-нд	\$ 76,747	\$ 28,625	\$ 19,905	\$ 125,277
2019.12.31-нд	\$ 61,698	\$ 22,722	\$ 21,578	\$ 105,998

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2019 болон 2020 оны 12 сарын 31-ний жилийн эцсийн тайлан

## 7. Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)

	Тээврийн ба хээрийн тоног төхөөрөмж	Тоног төхөөрөмж, тавилга	Програм хангамж, компьютер	Нийт
<b>Зардал</b>				
2020.01.01 үлдэгдэл	\$ 90,181	\$ 107,440	\$ 216,827	\$ 414,448
Нэмэгдэл	82,169	92,578	12,453	187,200
Борлуулалт	(32,868)	(2,478)	(3,596)	(38,942)
Валютын ханшийн шилжилтийн нөлөө	(7,734)	(6,540)	(1,731)	(16,005)
<b>2020.12.31 үлдэгдэл</b>	<b>\$ 131,748</b>	<b>\$ 191,000</b>	<b>\$ 223,953</b>	<b>\$ 546,701</b>
<b>Элэгдэл ба хорогдол</b>				
2020.01.01 үлдэгдэл	\$ (28,483)	\$ (84,718)	\$ (195,249)	\$ (308,450)
элэгдэл	(9,973)	(5,996)	(9,040)	(25,009)
Борлуулалт	15,338	2,478	3,596	21,412
Валютын ханшийн шилжилтийн нөлөө	1,532	1,812	1,433	4,777
<b>2020.12.31 үлдэгдэл</b>	<b>\$ (21,586)</b>	<b>\$ (86,424)</b>	<b>\$ (199,260)</b>	<b>\$ (307,270)</b>
<b>Дансны дүн</b>				
2020.01.01-нд	\$ 61,698	\$ 22,722	\$ 21,578	\$ 105,998
<b>2020.12.31-нд</b>	<b>\$ 110,162</b>	<b>\$ 104,576</b>	<b>\$ 24,693</b>	<b>\$ 239,431</b>

## 8. Гэрээгээр хүлээсэн үүрэг

Компани нь Алтан Нар ба Хөндий тусгай зөвшөөрлийн хүрээнд 1%-ийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөр ("NSR")-ийг Сэндсормд төлөх үүрэг хүлээсэн. Сэндсорм нь Алтан Нар болон Хөндий тусгай зөвшөөрлийн хувьд ирээдүйн роялти ба стрийм санхүүжилттэй холбоотой давуу эрх эдлэх нөхцөлтэй.

Галлант Минералз Лимитед нь Зуун Мод ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд 1.5%-ийн NSR хүлээн авах эрхтэй. Энэхүү гэрээний хүрээнд Компани нь Зуун Мод ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хайгуулын ажил гүйцэтгэх үүрэг хүлээгээгүй.

## 9. Хөрвөх нөхцөлтэй зээлийн тухай

2019 оны 10 сарын 11-нд Эрдэнэ Ресурс нь Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк ("EBRD")-аас 5 сая ам.доллар (6.6 сая кан.доллар)-ын хөрвөх нөхцөлтэй зээл авсан. Анхны санхүүжилтийн 2.5 сая ам.долларын гүйлгээ 2019 оны 11 сарын 4-нд, хоёр дахь санхүүжилт болон 2.5 сая ам.долларын гүйлгээ 2019 оны 11 сарын 25-нд хийгдсэн.

2020 оны 10 сарын 9-нд ЕСБХБ нь хөрвөх нөхцөлтэй зээлийн нөхцөлийн дагуу хөрвүүлэх опционыг хэрэгжүүлж, Компанийн 30,043,290 энгийн хувьцаа болгон хөрвүүлсэн. Түүнээс гадна, Компани нь ЕСБХБ-нд зээлийг эцэслэх хүртэл хуримтлагдсан зээлийн хүү болох US\$457,639-ыг төлсөн. \$5,429,703-ын үндсэн өр төлбөрийн дансны үнэ, хөрвүүлэлтийн өдөр тооцогдсон \$10,339,232-ын хөрвүүлэлтийн опционы бодит үнэ цэн нь өр төлбөрийг эцэслэн хувь нийлүүлсэн хөрөнгийн нэмэгдэлд бүртгэгдсэн.

Хөрвөх зээлийн үндсэн нөхцөлүүд:

- Зээлийн нийт дүн 5 сая ам.доллар байна
- Эрдэнэ Ресурсийн сонголтоор жил тутамд бэлэн мөнгө эсвэл өөр хэлбэрээр төлөх 10%-ийн хүү



# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2019 болон 2020 оны 12 сарын 31-ний жилийн эцсийн тайлан

## 9 Хөрвөх нөхцөлтэй зээлийн тухай (үргэлжлэл)

- Нэг, хоёр, гурван жилийн хугацаанд нэгж хувьцааг \$0.20 канад доллараар үнэлж, жил тус бүр 10%, 20%, 30%-ийн нэмэгдэл үнэлгээтэйгээр EBRD-ийн сонголтоор хэсэгчлэн болон бүтнээр компанийн Энгийн хувьцаанд хөрвүүлэх боломжтой.
- Хөрвүүлэлтийн өдрөөр тасалбар болсон капиталжуулсан хүүгийн хэмжээг ЕСБХБ нь Компанийн энгийн хувьцааны зах зээлийн ханшаар тооцон, эсвэл бэлэн мөнгөөр хүлээн авах боломжтой. (5 өдрийн жигнэсэн дундаж үнээр тооцно)

Нягтлан бодох бүртгэлийн зорилгоор Зээл нь холимог санхүүгийн хэрэглүүрт орох ба үүнд: зээлийн үндсэн үүрэг, хөрвүүлэлт ба урьдчилгаа төлбөрийн шинж чанаруудыг багтаасан үүсмэл санхүүгийн хэрэгслүүд орно. Компани нь зээлийн үүргийг зээлийн хугацааны эцэс хүртэл хуримтлагдсан өртгөөр тооцно. Хөрвүүлэлт ба урьдчилгаа төлбөрийн опционыг ашиг эсвэл алдагдлын бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн өр төлбөр болгон тооцно.

Зээл олгосон өдөр зээлийн бүрэлдэхүүн хэсгүүдийг бодит үнэ цэнээр үнэлснийг доорх хүснэгтэд харуулав:

Олгосон өдрийн өр төлбөрийн бүрэлдэхүүн	\$	4,505,902
Олгосон өдрийн хөрвүүлэлт, урьдчилан төлөх опцион		2,106,123
Санхүүгийн зардал		(254,262)
Цэвэр орлого	\$	6,357,763

2019 болон 2020 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон хугацааны өр төлбөрийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт:

	2020	2019
1 сарын 1-нд	\$ 4,333,370	\$ -
Дансны үнэ, хугацааны эхэнд	-	4,251,640
Капиталжуулсан хүүгийн зардал	608,302	84,978
Хорогдуулалтын нэмэгдэл	1,044,876	77,073
Валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	51,457	(80,321)
Бага: Хүү төлсөн	(608,302)	-
Бага: Зээлийн хөрвүүлэлт	(5,429,703)	-
12 сарын 31-нд	\$ -	\$ 4,333,370

Доорх хүснэгтээр 2019, 2020 оны 12 сарын 31-ны байдлаар зээлийн опционы хөрвүүлэлтийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийг харуулав:

	12 сарын 31 2020	12 сарын 31 2019
Дансны үнэ, хугацааны эхэнд	\$ 1,927,151	\$ 2,106,123
Бодит үнэ цэнийн тохируулга	8,508,076	(178,972)
Валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	(95,995)	-
Бага: Зээлийн хөрвүүлэлт	(10,339,232)	-
Хаалтын үлдэгдэл	\$ -	\$ 1,927,151

Хөрвөх опционыг бодит үнэ цэнээр бүртгэсэн ба үнэ цэнийг биномын опционы үнэлгээний загварт тулгуурлан, дараах үндсэн төсөөллүүдийг ашиглан тодорхойлсон:

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2019 болон 2020 оны 12 сарын 31-ний жилийн эцсийн тайлан

## 9 Хөрвөх нөхцөлтэй зээлийн тухай (үргэлжлэл)

	2020 оны 10 сарын 9- нд хөрвүүлсэн	2019 оны 12 сарын 31-нд тасалбар болсон
Хэлбэлзэл	79%	65%
Эрсдэлгүй хүүгийн хэмжээ	0.2%	1.6%
Опционы хөрвөх хугацаа	2.0 years	2.8 years
Зээлийн тархалт	24.8%	27.4%
Хувьцааны үндсэн үнэ	\$ 0.490	\$ 0.175
Валютын ханш (C\$:US\$)	0.762	0.770

## 10. Орлогын татвар

Компанийн орлогын албан татварт байгуулсан сан нь Канад Улсын холбооны татвар болон мужийн татварын хувийг нэгтгэж тооцсон дүнгээс орлогын татварын өмнөх орлого алдагдлын дүнг тооцсон тооцоололтоос гарах зөрүүг доорх хүснэгтэд үзүүлсэн.

	12 сарын 31 2020	12 сарын 31 2019
Албан татварын хувь хэмжээ	29.5%	31.0%
Албан татварын хувь хэмжээгээр тооцсон орлогын татвар (нөхөгдөх)	\$ (3,869,000)	\$ (832,000)
Түр хугацааны тооцогдоогүй зөрүүгийн ашиг	520,000	439,000
Татварын зорилгоор хасагдах боломжгүй зардлууд	3,221,000	239,000
Гадаад улсын татварын хувь хэмжээний нөлөө	128,000	154,000
Орлогын албан татварт байгуулсан сан	\$ -	\$ -

Татварын хувь хэмжээг татварын тооцоололдоо ашиглахад: Канад Улсад 29.5% (2019 онд 31% байсан), Монгол Улсад 25% (2019 онд 25% байсан).

Дараах хүснэгт нь Компанийн хойшлуулсан татварын хөрөнгө (алдагдал)-ийг харуулав:

	12 сарын 31 2020	12 сарын 31 2019
Урагшлуулсан хөрөнгийн бус алдагдал	\$ 495,000	\$ 754,000
Хойшлуулсан орлогын татварын хөрөнгө	495,000	754,000
Хөрвөх нөхцөлтэй зээл	-	(80,000)
Хэрэгжээгүй гадаад валют	(495,000)	(674,000)
Хойшлуулсан цэвэр орлогын татварын хөрөнгө (өр төлбөр)	\$ -	\$ -

Дараах түр хугацааны зөрүү, хөрөнгийн бус алдагдлууд болон хөрөнгийн алдагдлуудыг санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгаагүй болно.

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2019 болон 2020 оны 12 сарын 31-ний жилийн эцсийн тайлан

## 10. Орлогын татвар (үргэлжлэл)

	2019.12.31		
	Канад улс	Монгол улс	Нийт
Хөрөнгийн бус алдагдал	\$ 16,297,000	\$ 1,683,000	\$ 17,980,000
Үндсэн хөрөнгө, үйлдвэр, тоног төхөөрөмж	239,000	-	239,000
Хувьцаа гаргасан зардал	1,248,000	-	1,248,000
Биет бус хөрөнгө	378,000	-	378,000
Хайгуул, үнэлгээний хөрөнгө	5,737,000	8,574,000	14,311,000
	\$ 23,899,000	\$ 10,257,000	\$ 34,156,000

  

	2020.12.31		
	Канад улс	Монгол улс	Нийт
Хөрөнгийн бус алдагдал	\$ 18,559,000	\$ 1,801,000	\$ 20,360,000
Үндсэн хөрөнгө, үйлдвэр тоног төхөөрөмж	250,000	-	250,000
Хувьцаа гаргасан зардал	1,678,000	-	1,678,000
Биет бус хөрөнгө	378,000	-	378,000
Хайгуул, үнэлгээний хөрөнгө	5,737,000	8,017,000	13,754,000
	\$ 26,602,000	\$ 9,818,000	\$ 36,420,000

2020 оны 12 сарын 31-ний байдлаар Компани ирээдүйд шилжүүлэн татвар ногдох орлого хорогдуулах хөрөнгийн бус алдагдлууд үүссэн. Энэхүү алдагдлуудаар татвар ногдох орлого хорогдуулах хугацааг доор үзүүлэв:

	12 сарын 31 2020	12 сарын 31 2019
2020	-	353,000
2021	410,000	438,000
2022	440,000	469,000
2023	396,000	423,000
2024	554,000	
Түүнээс цааш	20,265,000	18,729,000
	\$ 22,065,000	\$ 20,412,000

## 11. Хувьцаат капитал, нэмэлт хөрөнгө

### Хувьцаа гаргах бүрэн эрх

Нэрлэсэн үнэгүй, хязгааргүй энгийн хувьцаа гаргах эрхтэй.

### Гаргасан хувьцаа

2020 оны 8 сарын 11-нд Компани нь нийт \$19,999,998 долларын санхүүжилтийг хаалттай хүрээнд татан төвлөрүүлсэн. Тус бүрийг \$0.45 доллараар үнэлсэн 33,333,333 нэгж захиалгын баримт ("Subscription Receipts")-ыг ноён Эрик Спроттын эзэмшдэг 2176423 Ontario Ltd хуулийн этгээд худалдан авч, түүнтэй зэрэгцэн тус бүрийг \$0.45 доллараар үнэлсэн 11,111,108 үнэт цаасны нэгжийг гаргасан. Захиалгын баримтууд нь Компанийн нэг энгийн хувьцаа болон энгийн хувьцаа худалдан авах эрх болох нэг варрант ("Варрант")-аас бүрдэнэ. Варрант бүр нь санхүүжилт хаагдсанаас хойш хоёр жилийн хугацаанд нэг энгийн хувьцааг \$0.60 доллараар худалдан авах эрхийг олгоно. Эдгээр захиалгын баримтыг 2020 оны 8

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

2019 болон 2020 оны 12 сарын 31-ний жилийн эцсийн тайлан

## 11. Хувьцаат капитал, нэмэлт хөрөнгө (үргэлжлэл)

сарын 11-нд энгийн хувьцаа эзэмшигчдийн 50%-аас их хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрөл болон шаардлагатай зохицуулагч байгууллага, Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны зөвшөөрлүүдийг авснаар хөрвүүлсэн. Хаалттай санхүүжилттэй холбоотойгоор нийт \$918,725 доллар болон 400,611 зуучлалын варрантыг гаргасан. Түүнээс гадна Компани нь хаалттай санхүүжилтийн хүрээнд үнэт цаас гаргах зардалд \$146,897 зарцуулан, нийт \$18,934,376 долларын цэвэр орлого төвлөрүүлсэн.

2019 онд Компани нь гурван удаа хаалттай хүрээнд хөрөнгө татан төвлөрүүлж, нэгж бүрийг \$0.21-ын жигнэсэн дундаж үнэ бүхий нийт 25,922,044 үнэт цаасны нэгжийг гарган, \$5,514,845 татан төвлөрүүлсэн. 25,922,044 үнэт цаасны нэгж нь 25,922,044 энгийн хувьцаа болон 18,938,614 варрантаас бүрдсэн. Варрантыг санхүүжилт хаагдсанаас хойш 2 жилийн хугацаанд дунджаар \$0.30 ба \$0.50 үнэлгээтэй хэрэгжүүлэх боломжтой. Компани нь хаалттай санхүүжилттэй холбоотой үйлчилгээний хураамжид \$116,176 төлж, 469,870 ширхэг варрантыг төлсөн. Түүнээс гадна санхүүжилттэй холбоотой зардалд \$88,804 төлж, нийт \$5,309,865 орлого төвлөрүүлсэн.

### Ирээдүйд олгогдох хувьцааны эрх ("DSU")

Ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн хөтөлбөрийг Компани 2013 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, албан тушаалтнуудыг урамшуулах хувьцааны опционы төлөвлөгөөтэй адил урт хугацааны хөрөнгө оруулагчдын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд ирээдүйд олгогдох хувьцааны нэгжийн тоо ширхэг хугацааг ТУЗ тодорхойлох бөгөөд дээрх эрхийг нөхөн төлбөр, урамшуулал болгох эсэхийг мөн тодорхойлно. Олгосон өдрөөс ирээдүйд олгогдох хувьцааны эрхийг шууд хэрэгжүүлэх боломжтой. Хугацаа дуусгавар болох, эсвэл хөтөлбөрт хамрагдсан гишүүн нас барсан тохиолдолд Компани тухайн гишүүний хувийг бэлэн мөнгөөр эсвэл үнэт цаасаар зах зээлийн үнэлгээгээр худалдан авах боломжтой. Энэ нь Компанийн сонголтоор хийгдэх бөгөөд Компани бэлэн мөнгөөр худалдан авахгүйгээр шийдвэрлэвэл энэхүү төлөвлөгөө нь үнэт цаасанд суурилсан хөтөлбөрт шилжинэ.

2020 оны 12 сарын 31-ний байдлаар Компани нь нэгж тус бүрийг дунджаар \$0.34 доллараар үнэлсэн 1,115,198 ширхэг ирээдүйд олгогдох хувьцааны эрх олгосон DSU (2019 – \$0.21 үнэлсэн 2,297,762 ширхэг ИОХЭ олгосон). Бодит үнэлгээ нь \$378,007 (2019 – \$462,010) бүхий ИОХЭ нь Захиргаа, удирдлагын зардал болон хайгуулын зардалд тусгагдсан. 2020 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцэст Эрдэнэ Ресурс нь ИОХЭ-ийн төлөвлөгөөнөөс нэгж бүр нь \$0.18 долларын үнэлгээ бүхий 719,212 хувьцааг гаргасан. (2019 – нэгж бүр нь \$0.18 долларын үнэлгээ бүхий 1,615,030 хувьцаа)

	2020.12.31-нд дуусгавар болсон	2019.12.31-нд дуусгавар болсон
Олгогдсон өдрөөс тооцоолсон 5 өдрийн жигнэсэн дундаж үнэ	\$ 0.34	\$ 0.21

2019, 2020 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн байдлаар ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн тухай мэдээлэл:

	2020.12.31 Тоо ширхэг	2019.12.31 Тоо ширхэг
1 сарын 1-ний байдлаар	4,636,850	3,954,118
Олгосон	1,115,198	2,297,762
Гаргасан	(719,212)	(1,615,030)
12 сарын 31-ний байдлаар	5,032,836	4,636,850

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2019 болон 2020 оны 12 сарын 31-ний жилийн эцсийн тайлан

## 11. Хувьцаат капитал, нэмэлт хөрөнгө (үргэлжлэл)

### Варрант

2020 оны 8 сарын 11-нд 44,845,052 ширхэг варрантыг хаалттай санхүүжилтийн хүрээнд гаргасан. Санхүүжилт хаагдсанаас хойш 24 сарын хугацаанд нэгж хувьцааг \$0.60 доллараар хэрэгжүүлэх боломжтой. Варрантын хугацаа 2022 оны 8 сарын 11-нд дуусна.

2019 онд Компани нь гурван удаа хаалттай хүрээнд хөрөнгө татан төвлөрүүлж, дунджаар \$0.30 ба \$0.50-аар хэрэгжүүлэх боломжтой 18,938,164 варрантыг гаргасан. Варрантууд нь 24 сарын хугацаанд хэрэгжих боломжтой. 2019 оны 2-р сарын байдлаар нийт 1,075,324 варрантын хугацаа дууссан.

2019, 2020 оны 12 сарын 31-ний байдлаар варрантын мэдээллийг доор харуулав:

	2020.12.31		2019.12.31	
	Варрантын тоо	Жигнэсэн дундаж хэрэгжих үнэ	Варрантын тоо	Жигнэсэн дундаж хэрэгжих үнэ
1 сарын 1-ний байдлаар	30,252,744	\$ 0.47	12,389,904	\$ 0.65
Гаргасан	44,845,052	0.60	18,938,164	0.39
Хэрэгжсэн	-	-	(1,075,324)	1.20
12 сарын 31-ний байдлаар гаргаса	75,097,796	\$ 0.55	30,252,744	\$ 0.47
12 сарын 31-ний байдлаар хэрэгжих боломжтой	75,097,796	\$ 0.55	30,252,744	\$ 0.47

2020 оны 12 сарын 31-ний байдлаар хэрэгжих боломжтой варрантын мэдээлэл

Хэрэгжүүлэх үнэ	Варрантын тоо	Гэрээний жигнэсэн дундаж хугацаа (үлдсэн жил)
\$0.30	7,653,550	0.63
\$0.40 - \$0.50	11,284,614	0.16
\$0.60	56,159,632	1.32
	75,097,796	1.08

Гаргасан варрант бүрийн үнэ цэнийг варрант гаргах үед Блэк Шолсийн опционы үнэлгээний загварыг ашиглан, жигнэсэн дундаж үнээр тогтоосон.

	2020.12.31		2019.12.31	
Гаргах өдрийн хувьцааны үнэ	\$	0.53	\$	0.20
Хэрэгжүүлэх үнэ	\$	0.60	\$	0.39
Эрсдэлгүй хүүгийн түвшин		0.3%		1.7%
Хүлээгдсэн хугацаа		2.0 жил		2.0 жил
Хүлээгдсэн хэлбэлзэл		70%		52%
Хүлээгдсэн ногдол ашиг		0.0%		0.0%
Гаргах өдрийн зах зээлийн жигнэсэн дундаж үнэ	\$	0.18	\$	0.02

Хүлээгдсэн хэлбэлзлийг үнэт цаасны түүхэн ханшийн хэлбэлзлийг харгалзан тооцсон.

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2019 болон 2020 оны 12 сарын 31-ний жилийн эцсийн тайлан

## 11, Хувьцаат капитал, нэмэлт хөрөнгө (үргэлжлэл)

### Хувьцаанд суурилсан нөхөн олговор

2020 оны 12 сарын 31-ний байдлаар Компани нь \$1,211,657 (2019 – \$703,060) долларын хувьцаанд суурилсан нөхөн төлбөрийн нэгтгэсэн алдагдалд зарлагадан, үүнээс \$522,970 (2019 – \$230,292) долларыг хайгуулын зардалд тооцсон.

### Хувьцааны опцион

Компани тогтмол 10%-ийн опционы урамшууллын хөтөлбөр (“Хөтөлбөр”) хэрэгжүүлдэг бөгөөд энэхүү хөтөлбөрийн хүрээнд Компанийн ТУЗ-ийн гишүүд, удирдлага, ажилтан албан тушаалтнууд компанийн хувьцааг худалдан авах опционыг худалдан авч, хэрэгжүүлэх боломжтой. Опционыг хэрэгжүүлэх, олгох нөхцөлүүдийг ТУЗ тодорхойлно. Опционыг олгохдоо нөхцөлийг өөрөөр заагаагүй бол олгосон өдрөөс эхлэн шууд хэрэгжүүлэх боломжтой. Төлөвлөгөөний хүрээнд энгийн хувьцааны хувьд олгох опцион нь Компанийн гаргасан болон зах зээлд буй энгийн хувьцааны 10%-аас хэтрэхгүй байх ба опционыг олгох шийдвэр гаргах үед нэг хүнд 5%-аас илүү олгох эрхгүй (хорогдуулахгүй байдалд үндэслэдэг).

2020 оны 12 сарын 31-ний байдлаар жигнэсэн дундаж хэрэгжүүлэх үнэ \$0.45 бүхий 3,910,000 опционыг олгосон. Мөн жигнэсэн дундаж хэрэгжүүлэх үнэ нь \$0.16 доллар бүхий 2,175,000 опционыг хэрэгжүүлж, \$344,300 орлого олсон. 2020 оны 12 сарын 31-ний байдлаар 250,000 ширхэг опционы хугацаа дууссан (2019 – 100,000 опцион).

2020 оны 12 сарын 31-нд тасалбар болсон жилийн эцэст \$0.45 жигнэсэн дундаж үнэ бүхий 3,910,000 опцион гаргасан (2019 – \$0.20 жигнэсэн дундаж үнэ бүхий 2,670,000 опцион). Нэгжийн дундаж үнэ \$0.16-аар үнэлэгдсэн 2,175,000 опцион хэрэгжсэн бөгөөд \$344,300 орлого төвлөрүүлсэн (2019 – нэгжийн дундаж үнэ \$0.15 -аар үнэлэгдсэн 1,105,000 опцион хэрэгжүүлж, \$169,800 орлого төвлөрүүлсэн). 2020 оны 12 сарын 31-нд тасалбар болгосон жилийн эцэст 250,000 опционы хугацаа дууссан (2019 – 100,000 опционы хугацаа дууссан).

2019, 2020 оны 12 сарын 31-ний байдлаар үнэт цаасны опционд гарсан өөрчлөлтүүд:

	2020.12.31		2019.12.31	
	Опционы тоо	Хэрэгжүүлэх боломжтой жигнэсэн дундаж үнэ	Опционы тоо	Хэрэгжүүлэх боломжтой жигнэсэн дундаж үнэ
1 сарын 1-ний байдлаар	12,305,000	\$ 0.41	11,335,000	\$ 0.43
Олгосон	3,910,000	0.45	2,670,000	0.20
Хугацаа дууссан/ Хэрэгжүүлээгүй	(250,000)	0.22	(595,000)	0.42
Хэрэгжүүлсэн	(2,175,000)	0.16	(1,105,000)	0.15
12 сарын 31-ний байдлаар гаргасан	13,790,000	\$ 0.46	12,305,000	\$ 0.41
12 сарын 31-ний байдлаар хэрэгжүүлэх боломжтой	13,790,000	\$ 0.46	12,305,000	\$ 0.41

2019 болон 2020 онд олгосон бүх опцион нь таван жилийн хугацаанд, шууд хэрэгжүүлэх боломжтой опцион юм. Доорх хүснэгтэд 2020 оны 12 сарын 31-ний байдлаар хэрэгжүүлэх боломжтой бүх гаргасан опционын мэдээллийг харуулав.

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2019 болон 2020 оны 12 сарын 31-ний жилийн эцсийн тайлан

## 11. Хувьцаат капитал, нэмэлт хөрөнгө (үргэлжлэл)

Дуусах хугацаа	2020.12.31		2019.12.31	
	Опционы тоо	Хэрэгжүүлэх үнэ	Опционы тоо	Хэрэгжүүлэх үнэ
05/06/20	-	\$ -	1,050,000	\$ 0.15
02/07/20	-	-	100,000	0.15
22/12/20	-	-	855,000	0.16
15/06/21	1,825,000	0.36	1,825,000	0.36
31/03/22	2,445,000	0.87	2,445,000	0.87
18/07/22	150,000	0.89	150,000	0.89
04/02/23	50,000	0.50	50,000	0.50
13/03/23	100,000	0.40	100,000	0.40
14/06/23	2,780,000	0.40	2,785,000	0.40
15/10/23	150,000	0.27	150,000	0.27
08/11/23	-	-	150,000	0.24
20/06/24	2,230,000	0.20	2,495,000	0.20
29/11/24	100,000	0.18	100,000	0.18
20/12/24	50,000	0.18	50,000	0.18
11/02/25	50,000	0.27	-	-
13/05/25	500,000	0.22	-	-
27/08/25	3,160,000	0.49	-	-
01/12/25	200,000	0.38	-	-
	13,790,000	\$ 0.46	12,305,000	\$ 0.41

Гаргасан опцион бүрийн үнэ цэнийг опцион гаргах үед Блэк Шолсийн опционы үнэлгээний загварыг ашиглан, жигнэсэн дундаж үнээр тогтоосон.

	2020.12.31	2019.12.31
Гаргах өдрийн хувьцааны үнэ	\$ 0.44	\$ 0.19
Хэрэгжүүлэх үнэ	\$ 0.45	\$ 0.20
Эрсдэлгүй хүүгийн түвшин	0.3%	1.4%
Хүлээгдсэн хугацаа	3.7 жил	3.8 жил
Хүлээгдсэн хэлбэлзэл	70%	63%
Хүлээгдсэн ногдол ашиг	0.0%	0.0%
Гаргах өдрийн зах зээлийн жигнэсэн дундаж үнэ	\$ 0.21	\$ 0.09

Хүлээгдсэн хэлбэлзлийг үнэт цаасны түүхэн ханшийн хэлбэлзлийг харгалзан тооцсон.

2020 онд гаргасан опцион нь хувьцаанд суурилсан нөхөн төлбөр ба захиргааны зардалд \$833,650 (2019 – \$241,050) долларын зардал хэлбэрээр тусгагдсан.

Дараах хүснэгтэд 2020 оны 12 сарын 31-ний байдлаар хэрэгжүүлж болох опционы хугацааг харуулав.

Үнэ	Хэрэгжүүлэх боломжтой опционы тоо	Гэрээний жигнэсэн дундаж хугацаа (үлдсэн жил)	Хэрэгжүүлэх боломжтой опционы жигнэсэн дундаж үнэ
\$0.14 - \$0.24	2,880,000	3.65	\$ 0.20
\$0.25 - \$0.49	8,265,000	2.93	0.42
\$0.50 - \$0.89	2,645,000	1.28	0.86
	13,790,000	2.76	\$ 0.46

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2019 болон 2020 оны 12 сарын 31-ний жилийн эцсийн тайлан

## 12. Хайгуул болон үнэлгээний зардал

2019, 2020 оны 12 сарын 31-ний байдлаар хайгуул болон үнэлгээний зардлын мэдээллийг доор хүснэгтэд харуулав.

	12 сарын 31	
	2020	2019
Элэгдэл хорогдол	\$ 17,541	\$ 14,224
Шууд зардал	522,761	650,482
Ажилтан, албан тушаалтнуудын нөхөн олговор	309,539	195,788
Хувьцаанд суурилсан нөхөн олговор	522,970	230,292
	\$ 1,372,811	\$ 1,090,786

## 13. Захиргаа, удирдлагын зардал

2019, 2020 оны 12 сарын 31-ний байдлаар захиргаа, удирдлагын зардлын мэдээллийг дор харуулав.

	12 сарын 31	
	2020	2019
Захиргааны үйлчилгээ	\$ 459,085	\$ 373,799
Элэгдэл, хорогдол	36,850	18,051
ТУЗ-ийн гишүүдийн төлбөр, нөхөн төлбөр	64,647	178,409
Хөрөнгө оруулагчтай харилцах, маркетинг	223,136	109,963
Оффис, бусад	81,221	107,841
Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	219,014	202,576
Зохицуулагч байгууллагын төлбөр, зардлууд	87,676	105,234
Хувьцаанд суурилсан нөхөн олговор	688,687	472,768
Томилолтын зардал	8,589	47,083
	\$ 1,868,905	\$ 1,615,724

## 14. Санхүүгийн хэрэглүүр

### Зээлийн эрсдэл:

Зээлийн эрсдэл нь санхүүгийн хөрөнгийн хамгийн өндөр эрсдэлийг агуулдаг. Тайлангийн өдрөөр тасалбар болгон зээлийн эрсдэл хамгийн их хүлээж буй хөрөнгийг харуулбал:

	Дансны дүн	
	12 сарын 31 2020	12 сарын 31 2019
Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах	\$ 12,800,728	\$ 5,106,863
Авлага	89,344	70,361
	\$ 12,890,072	\$ 5,177,224

Компани нь бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийг Канад Улсын тэргүүлэгч санхүүгийн байгууллагуудад байршуулж, зээлийн эрсдэлээ удирддаг. Ингэснээр алдагдлыг хамгийн бага хэмжээнд байлган, эрсдэлийг бууруулна гэж Компани үздэг. 2020 оны 12-р сарын 31-ний байдлаарх бэлэн мөнгөний үлдэгдлийн 1% буюу \$133,130 долларыг Канад Улсаас гадуурх банкуудад байршуулсан. (2019 - \$60,511 or 1%).



# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2019 болон 2020 оны 12 сарын 31-ний жилийн эцсийн тайлан

## 14. Санхүүгийн хэрэглүүр (үргэлжлэл)

### Төлбөрийн чадварын эрсдэл:

Компанийн хөрвөх чадварын эрсдэл нь өр төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулах үүргээ биелүүлэхэд үүсэж болзошгүй хүндрэлтэй холбоотой эрсдэлийг хэлнэ. Компани нь энэхүү эрсдэлийн удирдлагын хүрээнд санхүүгийн хэвийн болон хүндрэлтэй аль ч нөхцөлд шаардлагагүй гарз хүлээхгүйн тулд санхүүгийн өр төлбөр төлөгдөх хугацаанд хангалттай хэмжээний нөөцтэй байх бодлого баримталдаг.

### Зах зээлийн эрсдэл:

Зах зээлийн эрсдэл нь үнэт цаасны ханш, таваарын зах зээл, валютын ханш, хүүгийн түвшин зэрэг зах зээлийн хүчин зүйлсээс шалтгаалан өөрчлөгдөх магадлалтай эрсдэлүүдийг хэлнэ.

#### а) Хүүгийн эрсдэл

2020 оны 12 сарын 31-ний байдлаар Компани нь хүүтэй зээл байхгүй тул хүүгийн эрсдэлд өртөхгүй болно.

#### б) Гадаад валютын эрсдэл

Компанийн үйл ажиллагааны голлох валют нь канад доллар бөгөөд охин компаниудын голлох валют нь монгол төгрөг юм. Түүнээс гадна, Компани нь америк доллараар санхүүжилт авч, зардлыг гаргасан. Иймээс канад долларын бусад валюттай харьцах хэлбэлзэл нь санхүүгийн хөрөнгө, өр төлбөр болон үйл ажиллагааны үр дүнд нөлөөлөх боломжтой. Валютын хөрвөх эрсдэл бүхий санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдэд ам.доллараар илэрхийлэгдэх бэлэн мөнгө, өглөг, хуримтлагдсан өр төлбөр, монгол төгрөгөөр илэрхийлэгдсэн бэлэн мөнгө, өглөг болон хуримтлагдсан өр төлбөр багтаж байна. Компани нь Канад Улсын банкуудад канад болон ам.доллар байршуулдаг.

Компанийн гадаад валют (ам.доллар)-ын эрсдэлд өртөх байдлыг доор харуулав.

	12.31 2020	12.31 2019
Мөнгө болон түүнтэй адилтгах	\$ 292,895	\$ 4,854,316
Худалдаа, бусад авлага	-	-
Худалдаа, бусад өглөг	(223,503)	(155,219)
Хөрвөх нөхцөлтэй зээл	-	(1,927,151)
	\$ 69,392	\$ 2,771,946

Ам.долларын ханшид орох 10%-ийн өөрчлөлт нь \$6,900 долларын цэвэр алдагдал дагуулах магадлалтай (2019.12.31 - \$277,200).

Компанийн гадаад валют (төгрөг)-ын эрсдэлд өртөх байдлыг доор харуулав.

	12.31 2020	12.31 2019
Мөнгө болон түүнтэй адилтгах	\$ 889	\$ 7,963
Худалдаа, бусад авлага	5,460	5,877
Trade and other payables	(87,043)	(69,501)
	\$ (80,694)	\$ (55,661)

Монгол төгрөгийн ханшид орох 10%-ийн өөрчлөлт нь \$8,100 долларын цэвэр алдагдал дагуулах магадлалтай (2019.12.31 - \$5,600).

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2019 болон 2020 оны 12 сарын 31-ний жилийн эцсийн тайлан

## 14. Санхүүгийн хэрэглүүр (үргэлжлэл)

### с) Үнийн эрсдэл

Компанийн санхүүгийн хэрэгслүүд нь эрдсийн хайгуул, олборлолтын салбарын таваарын үнийн хэлбэлзлээс бусад байдлаар үнийн шууд эрсдэлд орох магадлал багатай.

### Бодит үнэ цэн:

Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан, тодруулгад тусгагдсан хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлоход бодит үнэ цэнийн ач холбогдлыг тусгасан шатлал ашигладаг. Үүнд:

Түвшин 1: Идэвхтэй зах зээлд нэг төрлийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн өгөгдөл нь тогтоосон үнэтэй байна.

Түвшин 2: Хөрөнгө болон өр төлбөрийн тогтоосон үнийн 1-р түвшинд багтсан үнээс бусад өгөгдөл шууд (жишээ нь үнэ) эсвэл шууд бус (жишээ нь үнээс гаралтай)

Түвшин 3: Өгөгдөл нь хэмжиж болохуйц бус (зах зээлийн үйл ажиллагаа бага, эсвэл огт дэмждэггүй) байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд бодит үнэ цэнээр бүртгэсэн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийн шатлалыг санхүүгийн тайлангийн тодруулгад дараах байдлаар тусгасан. Үүнд:

	2020.12.31			2019.12.31		
	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3
Бодит үнэ цэнээр хэмжигдсэн хөрөнгө						
Мөнгө болон түүнтэй адилтгах	\$ 12,800,728	\$ -	\$ -	\$ 5,106,863	\$ -	\$ -
Авлага	-	89,344	-	-	70,361	-
Хөрвөх нөхцөлтэй зээлийн хөрвүүлэх боломжтой опцион	-	-	-	-	(1,927,151)	-

## 16. Холбогдох талууд

Компанийн голлох удирдлагын ажилтнуудад ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх албан тушаалтнууд багтдаг. Эдгээр голлох удирдлагын ажилтнуудын цалин урамшууллыг доор харуулав:

	12.31	
	2020	2019
ТУЗ-ийн гишүүдийн цалин	\$ 63,199	\$ 104,567
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр	440,500	212,700
Ажилтнуудын цалин, урамшуулал	1,136,357	944,699
Голлох албан тушаалтнуудын хувьцаанд суурилсан нөхөн төлбөр	386,099	284,326
	\$ 2,026,155	\$ 1,546,292

2020 оны 12 сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд Компанийн тодорхой ажилтнууд, гүйцэтгэх удирдлага, ТУЗ-ийн гишүүд богино хугацааны урьдчилгааг хүлээн авсан. 2020 оны 12 сарын 31-ээр дуусгавар болсон хугацаанд урьдчилгаа төлбөрийг бүрэн төлж барагдуулсан.

*Орчуулга: Энэхүү тайлан нь англи хэл дээр бэлтгэгдсэн албан тайлангийн орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх мэдээлэл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.*